



**ЗАМ ТЭЭВЭР**

**2025**



**СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ**



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС  
2025 ОН

## АГУУЛГА

ТОВЧ ТАЙЛБАР .....	5
БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....	7
Ачаа тээвэр .....	7
Зорчигч тээвэр.....	13
БҮЛЭГ 2. АВТО ЗАМЫН САЛБАР .....	15
БҮЛЭГ 3. АВТОТЭЭВРИЙН САЛБАР .....	18
Зорчигч тээвэр.....	18
Ачаа тээвэр .....	19
Тээврийн хэрэгслийн бүртгэл .....	22
БҮЛЭГ 4. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....	25
Зорчигч тээвэр.....	26
Ачаа тээвэр .....	27
БҮЛЭГ 5. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....	34
Зорчигч тээвэр.....	35
Ачаа тээвэр .....	38
Нислэг гүйцэтгэл .....	39
БҮЛЭГ 6. ДАЛАЙН ТЭЭВЭР УСАН ЗАМЫН САЛБАР .....	40
Зорчигч тээвэр.....	40
Тээврийн хэрэгслийн бүртгэл .....	40
Монгол улсын далбаатай хөлөг онгоцны бүртгэл .....	41
ХАВСРАЛТ .....	43

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1 Нийт тээсэн ачаа.....	7
Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт .....	8
Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин .....	8
Зураг 4 Ачаа эргэлт, сая тн.км .....	8
Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар.....	9
Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр.....	9
Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, тээвэрлэлтийн төрлөөр.....	10
Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин .....	10
Зураг 9 Тээвэрлэлтийн төрөл, салбараар.....	11
Зураг 10 Улс хоорондын ачаа тээвэр .....	11
Зураг 11 Ачаа гаргалт (экспорт).....	12
Зураг 12 Ачаа оруулалт (импорт) .....	12
Зураг 13 Төмөр замын дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин.....	12
Зураг 14 Зорчигч тээвэр.....	13
Зураг 15 Зорчигч тээврийн өөрчлөлт .....	14
Зураг 16 Зорчигч тээврийн эзлэх хувь .....	14
Зураг 17 Олон улсын зорчигч тээвэр.....	14
Зураг 18 Орон нутгийн зорчигч тээвэр.....	14
Зураг 19 Зорчигч эргэлт, сая хүн/км.....	15
Зураг 20 Улсын чанартай авто зам .....	16
Зураг 21 Орон нутгийн чанартай авто зам .....	16
Зураг 22 Тусгай зориулалтын авто зам .....	16
Зураг 23 Улсын чанартай авто замын гүүр.....	16
Зураг 24 Улсын чанартай авто замын сүлжээ .....	17
Зураг 25 Автотээврийн зорчигч, сая хүн .....	18
Зураг 26 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр.....	18
Зураг 27 Автотээврийн зорчигч эргэлт.....	18
Зураг 28 Автотээврийн экспортын ачаа .....	19
Зураг 29 Экспортын ачаа, эзлэх хувь.....	20
Зураг 30 Автотээврийн импортын ачаа.....	20
Зураг 31 Боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгсэл, эзлэх хувь .....	21
Зураг 32 Тээврийн хэрэгслийн ангилал.....	22
Зураг 33 Жолооны хүрдний байрлал.....	22
Зураг 34 Хөдөлгүүрийн багтаамж.....	22
Зураг 35 Тээврийн хэрэгслийн импорт – улсаар, тээврийн хэрэгслийн төрлөөр.....	23
Зураг 36 Автомашины насжилт .....	23
Зураг 37 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн тоо .....	25
Зураг 38 Төмөр замын зорчигч эргэлт .....	26
Зураг 39 Төмөр замын ачаа эргэлт .....	27
Зураг 40 Төмөр замын тээвэрлэлтэд эзлэх хувь.....	28
Зураг 41 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин.....	28
Зураг 42 Төмөр замын улс хоорондын ачаа тээвэр, эзлэх хувь.....	28
Зураг 43 Төмөр замын экспортын тээврийн хэмжээ, эзлэх хувь.....	28
Зураг 44 Төмөр замын импортын тээврийн хэмжээ, эзлэх хувь.....	29

Зураг 45 Төмөр замаар дамжин өнгөрсөн ачаа тээврийн хэмжээ, эзлэх хувь .....	29
Зураг 46 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх хувь .....	29
Зураг 47 Төмөр замаар тээсэн ачааны төрөл .....	29
Зураг 48 Төмөр замаар тээсэн ачааны өөрчлөлт .....	29
Зураг 49 Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл .....	30
Зураг 50 Хүлээн авсан вагон .....	31
Зураг 51 Хүлээлгэн өгсөн вагон .....	31
Зураг 52 Хөдлөх бүрэлдэхүүний төрөл .....	32
Зураг 53 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч .....	32
Зураг 54 Төмөр замын сүлжээний урт .....	33
Зураг 55 Суурь бүтэц эзэмшигч .....	33
Зураг 56 Монгол Улсын үндэсний төмөр замын сүлжээ .....	34
Зураг 57 Олон улс, орон нутагт зорчигчдын эзлэх хувь .....	35
Зураг 58 Зорчигч тээврийн үзүүлэлтүүд .....	35
Зураг 59 Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр .....	36
Зураг 60 Олон улсын зорчигч, чиглэлээр .....	36
Зураг 61 Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгчээр .....	36
Зураг 62 Орон нутгийн зорчигч, чиглэлээр .....	36
Зураг 63 Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгчээр .....	37
Зураг 64 Ачаа, шуудангийн эзлэх хувь .....	38
Зураг 65 Ачаа тээврийн үзүүлэлт .....	38
Зураг 66 Нислэгийн үзүүлэлт .....	39
Зураг 67 Салбарын орлогын үзүүлэлт .....	39
Зураг 68 Усан замын зорчигч тээвэр .....	40
Зураг 69 Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл .....	40
Зураг 70 Усан замын тээврийн хэрэгсэл, аймгаар .....	40
Зураг 71 Техник хяналтын үзлэгийн дүн .....	40
Зураг 72 Бүртгэлтэй хөлөг онгоцны тоо .....	41
Зураг 73 Далайд тээсэн ачааны нэр төрөл .....	42

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт*
<b>Тээсэн ачаа</b>	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
<b>Ачаа эргэлт</b>	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
<b>Тээсэн зорчигч</b>	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
<b>Зорчигч эргэлт</b>	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

**Шилжүүлсэн тн.км** Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.

**Тээврийн орлого** Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

---

\*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

### Хянасан:

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баянзул

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, стандарт, статистикийн хэлтсийн дарга Д.Гэрэлням

### Боловсруулсан:

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, стандарт, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Нэмэхжаргал

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, стандарт, статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхзаяа

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ<sup>1</sup> бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

---

<sup>1</sup> Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

## ТОВЧ ТАЙЛБАР

Зам, тээврийн яамнаас тээвэр зохион байгуулалтын шуурхай, найдвартай байдлыг хангах, бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлж ажилласны үр дүнд ачаа болон зорчигч тээврийн хэмжээ нэмэгдлээ.

### Ачаа тээвэр

Зам, тээврийн салбар 2025 онд бүх төрлийн тээврээр нийт 146.5 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 9.5%-аар өслөө. Мөн ачаа эргэлт 2024 онд 34,595.5 сая тн.км байсан бол 2025 онд 37,575.9 сая тн.км болж 8.6%-аар өслөө.

Нийт ачаа тээврийн 65.9%-ийг автотээвэр, 34.09%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Автотээврийн ачаа 96.5 сая тонн болж өмнөх оноос 9.9%-аар, төмөр замын тээврийн ачаа 49.9 сая тонн болж өмнөх оноос 8.8%-аар, агаарын тээврийн ачаа 12.5 мянган тонн болж өмнөх оноос 20.3%-аар тус тус өссөн байна.

2025 онд нийт 146.5 сая тонн ачаа тээвэрлэснээс 130.9 сая тонн буюу 90.2%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 15.6 сая тонн буюу 9.8%-ийг бусад эдийн засгийн салбарын ачаа эзэлж байна.

2025 онд автотээврээр тээвэрлэсэн ачааны 95.8%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 76.9% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна. Харин бусад салбарын бүтээгдэхүүний ачаа тээврийн хэмжээ өмнөх оноос 19.2%-аар өссөн байна.

2024 онд улс хоорондын ачаа тээвэр 103.2 сая тонн болж нийт ачаа тээврийн 77.2%-ийг эзэлж байсан бол 2025 онд 112.1 сая тонн болж нийт ачаа тээврийн 76.5%-ийг эзэлж байна.

Үүнээс экспортын ачаа нийт ачаа тээврийн 71.2%-ийг эзэлж байгаа бөгөөд 2025 онд 104.3 сая тонн болж өмнөх оноос 9.0%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин импортын ачаа 7.8 сая тонн болж өмнөх оноос 3.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн 2025 онд дотоодын ачаа 28.4 сая тонн болж өмнөх оноос 12.8%, төмөр замаар

дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 5.9 сая тонн болж өмнөх оноос 12.2%-аар тус тус өсжээ.

2025 онд тээсэн улс хоорондын ачаа тээврийн 96.9% нь БНХАУ-тай, 3.1% нь ОХУ-тай хиллэж буй боомтоор орж, гарсан байна. БНХАУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 95.7% экспортын ачаа байгаа бол ОХУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 93.8% нь импортын ачаа байна.

Монгол Улсын далбаатай хөлөг онгоцоор 2023 онд нийт 268,231.28 MTS буюу 295,647.61 тонн ачаа, 2024 нийт 3,320,420.54 MTS буюу 3,660,140.11 тонн ачаа тээвэрлэсэн бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 332,742.94 MTS буюу 366,786.6 тонн ачаа тээвэрлэжээ

### Зорчигч тээвэр

2025 онд бүх төрлийн тээврээр нийт 179.8 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 16.1%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 173.4 саяд хүрсэн байна.

Бүх төрлийн тээврээр олон улс болон орон нутагт зорчигчдын тоо 2025 онд 6.5 сая болж өмнөх оноос 3.6%-аар өслөө. Үүнээс агаарын тээврээр 2.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 13.0%, усан замаар 111.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 18.3%, автотээврээр 2.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 7.2%-аар тус тус өссөн бол төмөр замаар 1.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 11.1%-аар буурчээ.

2025 онд олон улсын зорчигч тээвэрлэлт өмнөх оноос 6.2%-аар өсч, 2.4 сая боллоо.

Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 2.0 сая болж өмнөх оноос 14.8%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчдын 85.2%-ийг эзэлж байна. Харин олон улсад төмөр замаар зорчигчийн тоо 3.4%-аар нэмэгдэж 42.6 мянга болсон байна.

### Тээврийн дэд бүтэц

*Авто зам*

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 111,916.7 км байдаг бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 14,909.0 км авто зам, орон

нутгийн чанартай 96,041.7 км авто зам, тусгай зориулалтын 966.0 км авто зам байна.

2025 онд нийт 330.3 км хатуу хучилттай авто зам, 217 урт метр гүүр шинээр ашиглалтад орууллаа. Ингэснээр олон улс, улсын чанартай 7,956.8 км, орон нутгийн чанартай 2,267.3 км, тусгай зориулалтын 966.0 км, нийт 11,190.1 км хатуу хучилттай авто замтай болоод байна.

2025 оны байдлаар 21 аймаг, 123 сум хатуу хучилттай авто замаар холбогдоод байна.

#### *Төмөр зам*

Сүүлийн 4 жилийн хугацаанд төмөр замын сүлжээний гол замын уртыг 935.1 км-ээр, салбар замын уртыг 204.2 км-ээр, нийт уртыг 1,139.3 км-ээр нэмэгдүүлжээ.

Ингэснээр Монгол Улсын төмөр замын сүлжээний нийт урт 3,368.8 км болсон бөгөөд үүнээс гол төмөр замын урт 2,420.1 км, салбар төмөр замын урт 948.7 км байна.

#### **Тээврийн хэрэгсэл**

##### *Автотээвэр*

2025 оны жилийн эцсийн байдлаар 1,418,891 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 79,935 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн буюу 6.0%-аар өссөн байна.

Улаанбаатар хотод 795,756 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 56.1%-ийг, орон нутагт 623,135 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 43.9%-ийг эзэлж байна.

2025 онд автотээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгт нийт тээврийн хэрэгслийн 71.3% хамрагдсан нь өмнөх оноос 3.6%-аар буурсан үзүүлэлт байна.

##### *Хөдлөх бүрэлдэхүүн*

Төмөр замын салбарт 2025 оны жилийн эцсийн байдлаар хөдлөх бүрэлдэхүүний нийт тоо 12,245 байгаагаас хагас вагон 7,849 тавцант вагон 1,748, зорчигчийн вагон 335, зүтгүүр 212, машин механизм 77, бусад 2,024 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байна.

##### *Агаарын хөлөг*

2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 58 агаарын хөлөг бүртгэлтэй байгаагаас нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй 32 агаарын хөлөг бүртгэлтэй байна.

##### *Усан замын тээврийн хэрэгсэл*

Монгол Улсад дотоодын усан замын 281 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оноос 48 буюу 20.6%-аар өссөн байна. 2025 онд 207 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нь өмнөх оноос 41.8%-аар өссөн байна.

#### **Бусад үзүүлэлт**

Монгол Улсад 2025 оны байдлаар автотээврийн хэрэгслийн 84,879 мэргэшсэн жолооч бүртгэгдсэн нь өмнөх оноос 8.8%-аар буурсан байна. Нийт мэргэшсэн жолоочийн 2.4% буюу 1,998 эмэгтэй мэргэшсэн жолооч бүртгэлтэй байна.

# БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

**2025 ОНД АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ 146.5 САЯ ТОНН БОЛЖ ТҮҮХЭН АМЖИЛТ ТОГТООЛОО.**

## Ачаа тээвэр


Бүх төрлийн тээврээр 2025 онд нийт 146.5 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 9.5%-аар өслөө. Үүнээс автотээврийн ачаа 96.5 сая тонн болж өмнөх оноос 9.9%, төмөр замын тээврийн ачаа 49.9 сая тонн болж өмнөх оноос 8.8%, агаарын тээврийн ачаа 12.5 мянган тонн болж өмнөх оноос 22.3%-аар тус тус өссөн байна.

Нийт ачаа эргэлт 2024 онд 34,595.5 сая тн.км байсан бол 2025 онд 37,575.9 сая тн.км болж 8.6%-аар өслөө.




Тээврийн төрөл	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Нийт тээсэн ачаа, мянган тонн</b>	<b>60,297.8</b>	<b>49,238.1</b>	<b>60,813.4</b>	<b>107,319.5</b>	<b>133,721.2</b>	<b>146,468.3</b>
Төмөр зам	29,840.1	31,261.4	27,724.9	36,114.2	45,899.1	49,929.3
Автотээвэр	30,455.0	17,970.3	33,075.6	71,196.7	87,811.7	96,526.5
Агаарын тээвэр	2.7	6.4	12.9	8.6	10.4	12.5
<b>Нийт ачаа эргэлт, сая тн.км</b>	<b>23,861.0</b>	<b>20,674.6</b>	<b>17,534.1</b>	<b>30,601.6</b>	<b>34,595.5</b>	<b>37,575.9</b>
Төмөр зам	19,167.6	18,345.1	14,910.2	18,869.3	21,217.6	23,292.4
Автотээвэр	4,685.3	2,313.9	2,591.9	11,707.9	13,348.9	14,255.3
Агаарын тээвэр	8.1	15.6	32.0	24.3	29	28.1

Зураг 1 Нийт тээсэн ачаа




2025 онд бүх төрлийн тээврээр тээсэн нийт ачаа болон авто тээвэр, төмөр замаар тээсэн ачааны хэмжээ тус тус түүхэн дээд үзүүлэлтэд хүрсэн бөгөөд 2020-2024 оны жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулбал, нийт тээсэн ачаа 77.9%, автотээврийн ачаа 2 дахин, төмөр замын тээврийн ачаа 46.1%-аар тус тус илүү байна.

Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт




2025 онд нийт ачаа тээврийн дүнд 65.67%-ийг автотээвэр, 34.32%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа тус тус эзэлж байсан бол 2025 онд 65.9%-ийг автотээвэр, 34.09%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээвэр эзэлж байна.

Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин



Зураг 4 Ачаа эргэлт, сая тн.км




2025 онд нийт ачаа эргэлт 37,575.9 сая тн.км болж 2020 оны түвшингээс 57.5%-аар өссөн бол өмнөх оноос 8.6%-аар өсжээ.

Автотээврийн ачаа эргэлт 2025 онд 14,255.3 сая тн.км болж өмнөх оноос 6.8%-аар, 2020 онтой харьцуулахад 3 дахин өссөн байна.

Нийт ачаа эргэлтэд төмөр замын ачаа эргэлт хамгийн өндөр үзүүлэлттэй хэвээр байна. 2025 онд 23,292.4 сая тн.км болж өмнөх оноос 9.8%, 2020 оны түвшингээс 21.5%-аар өсчээ.

Агаарын тээврийн ачаа эргэлт 28.1 сая тн.км болж 2020 онтой харьцуулахад 3.5 дахин өссөн бол өмнөх оноос 3.1%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар




2025 онд нийт 146.5 сая тонн ачаа тээвэрлэснээс 130.9 сая тонн буюу 90.2%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 15.6 сая тонн буюу 9.8%-ийг бусад эдийн засгийн салбарын ачаа эзэлж байна.

Эдийн засгийн салбарын ачаа тээврийн өөрчлөлт нь тухайн салбарын өсөлт, бууралттай шууд хамааралтай бөгөөд 2025 онд автотээвэрээр тээвэрлэсэн ачааны 95.8%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 76.9% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна. Харин бусад салбарын бүтээгдэхүүний ачаа тээврийн хэмжээ өмнөх оноос 19.2%-аар өссөн байна.


Уул уурхайн олборлолт болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэж, экспортын тээврийн 98.1%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн 90.5% буюу 92.4 сая тонн ачааг автотээвэрээр, 9.5% буюу 9.7 сая тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна.

Экспортод болон дотоодод тээвэрлэсэн уул уурхайн бүтээгдэхүүнийг бүтээгдэхүүнээр авч үзвэл, 109.1 сая тонн буюу 84.5%-ийг нүүрс, 13.8 сая тонн буюу 10.7%-ийг төмрийн хүдэр, 2.3 сая тонн буюу 1.8%-ийг зэсийн баяжмал, 2.0 сая тонн буюу 1.6%-ийг жонш, 1.0 сая тонн буюу 1.0%-ийг нефть, газрын тос, 151.3 мянган тонн буюу 0.1%-ийг цайрын баяжмал, 501.2 мянган тонн буюу 0.4%-ийг бусад ашигт малтмал тус тус эзэлж байна.

Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр



Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, тээвэрлэлтийн төрлөөр




2025 онд ачаа тээврийн хэмжээ тээвэрлэлтийн бүх төрлөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Тээврийн төрөл	2024 он	2025 он
<b>Нийт тээсэн ачаа, сая тонн</b>		<b>133,721.2</b>	<b>146,468.3</b>
<b>Транзит</b>	Төмөр зам	<b>5,299.2</b>	<b>5,945.2</b>
	Автотээвэр	11,610.1	11,687.6
<b>Экспорт</b>	Төмөр зам	84,028.3	92,583.1
	Автотээвэр	<b>95,683.4</b>	<b>104,270.7</b>
<b>Импорт</b>	Төмөр зам	3,794.2	3,870.3
	Автотээвэр	3,783.4	3,943.4
<b>Дотоодод</b>	Төмөр зам	<b>7,577.6</b>	<b>7,813.7</b>
	Агаар	25,195.5	28,426.2
<b>Нийт</b>		<b>25,205.9</b>	<b>28,438.7</b>

Бүх төрлийн тээврээр тээсэн экспортын ачаа 104.3 сая тонн болж өмнөх оноос 9%-аар, дотоодын ачаа 28.4 сая тонн

болж өмнөх оноос 12.8%, импортын ачаа 7.8 сая тонн болж өмнөх оноос 3.1%-аар, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 5.9 сая тонн болж өмнөх оноос 12.2%-аар тус тус өсжээ.

Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин




Экспортын ачаа 9%-аар өссөн хэдий ч 2024 онд 71.5%-ийг эзэлж байсан экспортын тээвэр 2025 онд 71.2% болж, импортын ачаа өмнөх оноос 3.1%-аар өссөн хэдий ч нийт тээврийн хэмжээнд эзлэх хувь 5.7%-аас 5.3% болж өөрчлөгджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын транзит тээврийн эзлэх хувь 4.1% байна.

Дотоодын ачаа тээвэр 2024 онд 25.2 сая тонн буюу нийт ачаа тээврийн 18.9%-ийг эзэлж байсан бол 2025 онд 28.4 сая тонн болж өссөн нь 19.4%-ийг эзэлжээ. Үүнээс харахад дотоодын ачаа тээврийн хэмжээ өсжээ.

Зураг 9 Тээвэрлэлтийн төрөл, салбараар



Улс хоорондын ачаа тээвэр буюу экспорт, импортын ачаа тээврийг төмөр зам, автотээврээр гүйцэтгэж байгаа бол транзит тээвэр болон дотоодын тээвэрт төмөр зам голлох үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улс өнөөдөр хоёр хөрштэйгөө төмөр замын 3 боомт, авто замын 18 боомтоор экспорт, импортын тээвэр хийж байна.


Төмөр замын боомтоор хоногт дунджаар өргөн царигаар 16.0, нарийн царигаар 7.6 галт тэрэг солилцож, солилцсон вагоны тоо 0.6 хувиар нэмэгдсэн нь төмөр замаар тээх экспортын ачаа нэмэгдэхэд нөлөөлжээ.

2025 онд автотээврээр экспортын ачааны 88.8%, импортын ачааны 50.5%-ийг

тээсэн бол төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 49.5%, экспортын ачааны 11.2%-ийг тээвэрлэжээ.

2024 онд улс хоорондын ачаа тээвэр 103.2 сая тонн болж нийт ачаа тээврийн 77.2%-ийг эзэлж байсан бол 2025 онд 112.1 сая тонн болж нийт ачаа тээврийн 76.5%-ийг эзэлж байна.

Зураг 10 Улс хоорондын ачаа тээвэр



- БНХАУ-тай хиллэх боомтын ачаа тээвэр
- ОХУ-тай хиллэх боомтын ачаа тээвэр

2025 онд тээсэн улс хоорондын ачаа тээврийн 96.9% нь БНХАУ-тай хиллэж буй 12 боомтоор, 3.1% нь ОХУ-тай хиллэж буй 6 боомтоор орж, гарсан байна.

Үүнээс хамгийн их буюу 38.5% Гашуунсухайт, 28.9% нь Шивээхүрэн, 14.5% нь Замын-Үүд, 5.5% нь Ханги боомтоор орж, гарсан бол Алтанбулаг боомтоор 3.2 сая тонн ачаа буюу 2.9% нь орж, гарчээ.

БНХАУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 95.7% экспортын ачаа байгаа бол ОХУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 93.8% нь импортын ачаа байна.

Монгол Улсын экспортын ачааны 99.8% БНХАУ руу гарсан бол импортын ачааны 59.5% нь БНХАУ-аас, 40.5% ОХУ-аас орж иржээ.

Зураг 11 Ачаа гаргалт (экспорт)



2025 онд Гашуунсухайт боомтоор хамгийн их буюу 42.6 сая тонн ачаа гарсан нь нийт ачаа гаргалтын 40.8%-ийг эзэлж байгаа бол Шивээхүрэн боомтоор 30.9%, Замын-Үүд боомтоор 11.9% нь гарчээ.

2025 онд нийт импортын ачааны 48.3% нь Замын-Үүд Алтанбулаг боомтоор, 38.6% нь Алтанбулаг боомтоор, 7.4% нь Гашуунсухайт боомтоор, 1.5% нь Цагааннуур боомтоор орж ирсэн бол 4.3% нь бусад боомтоор орж иржээ.

Зураг 12 Ачаа оруулалт (импорт)




Замын-Үүд боомтоор БНХАУ-аас орж ирж буй импортын ачааны 81.2% буюу 3.8 сая тонн

ачаа, Гашуунсухайтын боомтоор 12.7% буюу 574.8 мянган тонн ачаа орж ирсэн бол Шивээхүрэн боомтоор 74.4 мянган тонн ачаа буюу 1.6% нь орж иржээ.

ОХУ-аас орж ирж буй импортын ачааны хувьд 95.2% буюу 3.0 сая тонн ачаа Алтанбулаг боомтоор орж ирсэн бол Цагааннуур боомтоор 3.6%, Боршоо боомтоор 1.1% нь орж ирсэн байна.

2025 онд төмөр замаар тээсэн дотоодын ачаа өмнөх оноос 12.8%-аар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд дотоодын төмөр замын байгууллагуудын ачаа тээвэрлэлт өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 13 Төмөр замын дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин



Төмөр замын байгууллагууд эрчим хүчний нүүрс, шахмал түлшний түүхий эдийн тээврийг бүрэн хариуцан нийгмийн хариуцлагын хүрээнд тээвэрлэсэн нь дотоодын ачааны өсөлтөд нөлөөлжээ.

2025 онд "Улаанбаатар төмөр зам" ХНН дотоодын ачааны 12.2 сая тонн буюу 43%-ийг, бусад төмөр замын байгууллагууд дотоодын ачааны 57%-ийг тээвэрлэжээ.

**2025 ОНД БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРЭЭР 179.8 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.**

### Зорчигч тээвэр


Бүх төрлийн тээврээр 2025 онд нийт 179.8 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 16.1%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 173.4 саяд хүрлээ.

Мөн агаарын тээврээр 2.4 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 13.0%, автотээврээр 175.5 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 16.5%, усан замаар 111.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 18.3%-аар тус тус өссөн бол төмөр замаар 1.8 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 11.1%-аар буурсан байна.



Тээврийн төрөл	2022	2023	2024	2025	2025/2024
<b>Нийт зорчигчдын тоо, сая хүн</b>	<b>146.3</b>	<b>146.5</b>	<b>154.8</b>	<b>179.8</b>	<b>16.1%</b>
Автотээвэр	143.0	142.6	150.6	175.5	16.5%
Төмөр замын тээвэр	2.4	2.1	2.0	1.8	-11.1%
Агаарын тээвэр	0.9	1.7	2.2	2.4	13.0%
Усан замын тээвэр	0.04	0.06	0.09	0.1	18.3%
<b>Зорчигч эргэлт, сая хүн.км</b>	<b>4,444.8</b>	<b>6,492.7</b>	<b>7,333.1</b>	<b>8,326.5</b>	<b>13.5%</b>
Автотээвэр	1,964.7	1,508.6	1,651.4	1,914.0	15.9%
Төмөр замын тээвэр	701.5	797.5	786.1	727.8	-7.4%
Агаарын тээвэр	1,828.4	3,880.8	4,894.0	5,683.0	16.1%
Усан замын тээвэр	0.9	1.2	1.6	1.7	6.5%

Зураг 14 Зорчигч тээвэр



2024 онд автотээврийн зорчигчийн 95.9%-ийг нийслэлийн тээврийн зорчигч эзэлж байсан ба 2025 онд мөн 96.4%-ийг эзэлж байгаа нь автотээврээр зорчсон зорчигчийн тоо өссөн


ба нийслэлийн тээврийн зорчигч мөн адил өссөнийг харуулж байна.

Үзүүлэлт	Тээврийн төрөл	2024 он	2025 он
----------	----------------	---------	---------

Нийт зорчигч		154,843.7	179,826.3
Олон улсад зорчигч	Автотээвэр	428.5	305.5
	Төмөр зам	41.2	42.6
	Агаарын тээвэр	1,746.9	2,006.2
	<b>Нийт</b>	<b>2,216.6</b>	<b>2,354.3</b>
Орон нутагт зорчигч	Автотээвэр	1,570.1	1,836.2
	Төмөр зам	1,935.3	1,715.1
	Агаарын тээвэр	420.4	442.3
	Усан зам	94.2	111.5
<b>Нийт</b>	<b>4,020.0</b>	<b>4,105.0</b>	
Нийслэлд зорчигч	Автотээвэр	148,607.0	173,367.7

2024 онд бүх төрлийн тээврээр улс хооронд болон хот хооронд зорчсон зорчигчдын тоо 6.2 сая байсан бол 2025 онд 6.5 сая болж өмнөх оноос 3.6%-аар өслөө.


Зураг 15 Зорчигч тээврийн өөрчлөлт



Улс хооронд болон орон нутагт агаарын тээврээр 2.4 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 13.0%, усан замаар 111.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 18.3%, автотээврээр 2.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 7.2%-аар тус тус өссөн бол төмөр замаар 1.8 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 11.1%-аар буурсан байна.


Тээврийн төрлөөр авч үзвэл 2025 онд улс хооронд болон хот хооронд зорчигчдын 33.2% нь автотээврээр, 27.2% нь төмөр замаар, 37.9% нь агаарын тээврээр, 1.7% нь усан замаар зорчсон байна.

Зураг 16 Зорчигч тээврийн эзлэх хувь



2025 онд олон улсад бүх төрлийн тээврийн хэрэгслээр нийт 2.4 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 6.2%-аар өслөө.

Зураг 17 Олон улсын зорчигч тээвэр




Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 2.0 сая болж өмнөх оноос 14.8%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчдын 85.2%-ийг эзэлж байна.

Харин автотээврийн олон улсын зорчигчдын тоо 2025 онд 305.5 мянга болж өмнөх оноос 28.7%-аар буурсан байна.

2023 оны 8 дугаар сараас төмөр замын олон улсын зорчигч тээврийг дахин эхлүүлсэн бөгөөд 2024 онд 41.2 мянган зорчигч тээвэрлэж байсан бол 2025 онд 42.6 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оноос 3.4%-аар өсжээ.

Бүх төрлийн тээврээр орон нутагт зорчигчдын тоо 2025 онд 4.1 сая байсан ба өмнөх оноос 2.1%-аар өссөн байна.

Зураг 18 Орон нутгийн зорчигч тээвэр



2025 онд автотээвэрээр орон нутагт зорчигчдын тоо өмнөх оноос 16.9%-аар өсч 1.8 сая болсон нь орон нутагт зорчигчдын 44.7%-ийг эзэлж байна. Мөн орон нутагт зорчигчдын 41.8%-ийг төмөр замын зорчигчид эзэлж байгаа бөгөөд 1.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 11.4%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Төмөр замаар орон нутагт зорчигчдын тоо буурахад төмөр замын зорчигч тээврийн тарифын өсөлт, зорчигч тээврийн вагоны насжилт болон авто замын нөхцөл байдал сайжирч, автотээвэрээр зорчигчдын тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зам, тээврийн яамнаас 2023 оноос орон нутгийн зорчигч тээврийн чиглэлд агаарын тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн нислэгийг сэргээх

бодлогыг баримтлан ажилласан бөгөөд 2024 онд агаарын тээвэрээр орон нутагт зорчигчдын тоо 420.4 мянгад хүрсэн бол 2025 онд 442.3 мянга болж өмнөх оноос 5.2%-аар өссөн байна.

2025 онд нийт зорчигч эргэлт 8,326.5 сая хүн.км болж өмнөх оноос 13.5%-аар өсжээ. Үүнээс агаарын тээврийн зорчигч эргэлт 16.1%-аар өсч 5,683.0 сая хүн.км, автотээврийн зорчигч эргэлт 15.9%-аар өсч 1,914 сая хүн.км болжээ. Харин төмөр замын тээврийн зорчигч эргэлт 7.4%-аар буурсан байна.


Зураг 19 Зорчигч эргэлт, сая хүн/км



## БҮЛЭГ 2. АВТО ЗАМЫН САЛБАР

**МОНГОЛ УЛС УЛСЫН ЧАНАРТАЙ 7,956.8 КМ, НИЙТ 11,190.1 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМТАЙ БАЙНА.**

Зураг 20 Улсын чанартай авто зам



Үндэсний авто замын сүлжээний нийт урт 111,916.7 км байдаг бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 14,909.0 км авто зам, орон нутгийн чанартай 96,041.7 км авто зам, тусгай зориулалтын 966.0 км авто зам байна.


Улсын чанартай 14,909.0 км авто замыг төрлөөр нь ангилбал, хатуу хучилттай авто зам 7,956.8 км, ердийн хөрсөн зам 5,631.7 км, сайжруулсан хөрсөн зам 311.5 км, хайрган хучилттай зам 1,009.0 км байна. Хатуу хучилттай авто замаас 7,932.1 км нь асфальт бетон, 24.7 км нь цемент бетон авто зам байна.

Үндэсний авто замын сүлжээний орон нутгийн чанартай 96,041.8 км авто замыг төрлөөр нь ангилбал, ердийн хөрсөн 93,126.0 км, сайжруулсан хөрсөн 393 км, хайрган хучилттай 255.4 км, хатуу хучилттай 2,267.3 км авто зам байна. Үүнээс хатуу хучилттай замыг 2,223.7 км асфальт бетон, 43.6 км цемент бетон авто зам бүрдүүлж байна.

Зураг 21 Орон нутгийн чанартай авто зам



Зураг 22 Тусгай зориулалтын авто зам




Тусгай зориулалтын хатуу хучилттай 966.0 км авто зам байгаагаас 922.8 км нь асфальт бетон, 43.2 км цемент бетон авто зам байна.


2025 онд улсын хэмжээнд нийт 217 урт метр гүүр шинээр ашиглалтад орууллаа.

Улсын чанартай авто зам дагуу нийт 17590.9 урт метр бүхий 397 гүүр байна. Үүнээс нийтдээ 16,265.2 урт метр 342 төмөр бетон гүүр, 284 урт метр 1 ган гүүр, 1041.7 урт метр 54 модон гүүр гүүр бүртгэлтэй байна.

Зураг 23 Улсын чанартай авто замын гүүр



Зураг 24 Улсын чанартай авто замын сүлжээ



**2025 онд нийт 330.3 км хатуу хучилттай авто замыг шинээр ашиглалтад орууллаа.** Үүнээс улсын чанартай 72.1 км хатуу хучилттай авто зам шинээр ашиглалтад оруулсан байна.

Ингэснээр олон улс, улсын чанартай 7,956.8 км, орон нутгийн чанартай 2,267.3 км, тусгай зориулалтын 966.0 км, нийт 11,190.1 км хатуу хучилттай авто замтай болоод байна.

Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг замын төрлөөр авч үзвэл 53% буюу 7,956.8 км хатуу хучилттай, 7.0% буюу 1009.0 км хайрган хучилттай, 2.0% буюу 311.5 км нь сайжруулсан хөрсөн зам байгаа бол 38.0% буюу 5,631.7 км нь ердийн хөрсөн зам байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Азийн авто замын сүлжээний босоо тэнхлэгийн АН-3 чиглэлийн, АН-4 болон хэвтээ тэнхлэгийн АН-32 чиглэл дайран өнгөрдөг.

## БҮЛЭГ 3. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

### АВТОТЭЭВРЭЭР УЛС, ХОТ ХООРОНД БОЛОН ХОТ ДОТОР НИЙТ 175.5 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.

#### Зорчигч тээвэр

2025 онд автотээвэрээр нийт 175.5 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 16.5%-аар, зорчигч эргэлт 1,914.0 сая хүн.км болж 15.9%-аар тус тус өссөн байна. Үүнд нийслэлийн нийтийн тээвэрээр 173.4 сая зорчигч зорчиж өмнөх оноос 16.7%-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хот хооронд буюу орон нутагт 1.8 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 16.9%-аар, зорчигч эргэлт 18.1%-аар тус тус өссөн бол олон улсад 305.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 28.7%-аар буурсан байна.



Зураг 25 Автотээврийн зорчигч, сая хүн

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2025 он	2025/2024
<b>Нийтийн тээвэрээр зорчсон нийт зорчигч</b>	мян.хүн	142,553.0	150,605.7	175,508.7	16.5%
Олон улс /улс хооронд/	мян.хүн	850.2	428.5	305.5	-28.7%
Орон нутаг /хот хооронд/	мян.хүн	1,417.1	1,570.1	1,836.2	16.9%
Нийслэлийн нийтийн тээвэр	мян.хүн	140,285.7	148,607.0	173,367.0	16.7%
<b>Зорчигч эргэлт</b>	сая хүн.км	1,508.6	1,651.4	1,914.0	15.9%
Олон улс /улс хооронд/	сая хүн.км	94.7	83.9	69.6	-17.0%
Орон нутаг /хот хооронд/	сая хүн.км	941.1	1,062.3	1,254.8	18.1%
Нийслэлийн нийтийн тээвэр	сая хүн.км	472.9	505.2	589.6	16.7%

Зураг 26 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр



Зураг 27 Автотээврийн зорчигч эргэлт



Нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчдын тоо өссөн нь автотээврийн зорчигч эргэлт өсөхөд голлон нөлөөлжээ. Автотээврийн зорчигч эргэлт нийт зорчигч эргэлтийн 23.3%-ийг эзэлж байна.

**АВТО ЗАМЫН ХИЛИЙН БООМТООР  
АВТОТЭЭВРЭЭР 96.5 САЯ ТОНН АЧАА  
ТЭЭВЭРЛЭЖ 9.9%-ААР ӨСЛӨӨ.**



**Ачаа тээвэр**

2025 онд авто замын боомтуудаар нийт 96.5 сая тонн ачаа тээвэрлэлээ.

2025 оны автотээврийн ачаа өмнөх оноос 9.9%-аар өссөн бөгөөд үүнээс нийт 92.6 сая тонн экспортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 10.2%, 3.9 сая тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 4.2%-аар тус тус өссөн байна.

Автотээврийн ачаа тээвэр	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2025 он	2025/2024
<b>Нийт тээсэн ачаа</b>	<b>мян.тонн</b>	<b>71,196.7</b>	<b>87,811.7</b>	<b>96,526.5</b>	<b>9.9%</b>
Ачаа оруулалт - импорт	мян.тонн	2,933.6	3,783.4	3,943.4	4.2%
БНХАУ-аас	мян.тонн	2,561.5	3,343.3	3,577.9	7.0%
ОХУ-аас	мян.тонн	372.1	440.1	365.4	-17.0%
Ачаа гаргалт - экспорт	мян.тонн	68,263.1	84,028.3	92,583.1	10.2%
БНХАУ руу	мян.тонн	68,236.7	83,996.4	92,538.4	10.2%
ОХУ руу	мян.тонн	26.4	31.9	44.7	40.2%
<b>Ачаа эргэлт</b>	<b>сая тн.км</b>	<b>11,707.9</b>	<b>13,348.9</b>	<b>14,255.3</b>	<b>6.8%</b>

2025 онд тээсэн нийт экспортын ачааны 88.8%-ийг автотээвэрээр тээжээ.

Зураг 28 Автотээврийн экспортын ачаа



Автотээврийн экспортын ачааны 99.9%-ийг БНХАУ-руу тээвэрлэсэн бол, 0.1%-ийг ОХУ-руу тээвэрлэжээ.

2025 онд авто замын 14 боомтоор нийт 92.5 сая ачаа экспортолсон нь өмнөх оноос 10.2%-аар өссөн үзүүлэлт юм. Үүнээс Гашуунсухайт боомтоор хамгийн их 46% буюу 42.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 5.6%, Шивээхүрэн боомтоор 34.9% буюу 32.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 31.6%, Бичигт боомтоор 6.3% буюу 5.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 42.3%, Хавирга боомтоор 287.6 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 5.1%-аар тус тус өсжээ. Харин Ханги 28.5%-аар, Булган 14.2%-аар, Замын-Үүд 9.7%-аар, Бургастай 1.2%-аар, Баянхошуу 13.5%-аар, Сүмбэр 17.9%-аар тус тус бууржээ.

ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 37.4 мянган тонн ачаа экспортолсон нь 28.7%-аар, Цагааннуур боомтоор 6.9 мянган тонн ачаа тээсэн нь 2 дахин өссөн байна. Мөн Боршоо боомтоор 240.4 тонн, Арцсуурь боомтоор 34 тонн ачаа тус тус экспортолжээ.

Зураг 29 Экспортын ачаа, эзлэх хувь



2025 онд автотээврээр 88.6 сая тонн нүүрс (+9.3%), 1.6 сая тонн зэсийн баяжмал (+53.4%), 1.1 сая тонн төмрийн хүдэр (+18.2), 436.3 мянган тонн газрын тос (-13.3%), 465.3 мянган тонн жонш тээвэрлэсэн нь 2.6 дахин тус тус өслөө. Мөн 73.6 мянган тонн цайр, 1.2 мянган тонн уул уурхайн бусад ашигт малтмал, 222.9 мянган тонн бусад ачаа экспортолсон байна.

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2025 он	2025/2024
Нүүрс	мян.тонн	66,158.6	81,090.6	88,608.5	9.3%
Зэсийн баяжмал	мян.тонн	854.8	1,073.7	1,646.9	53.4%
Төмрийн хүдэр	мян.тонн	368.9	954.8	1,128.3	18.2%
Жонш	мян.тонн	65.0	178.5	465.3	160.6%
Газрын тос	мян.тонн	581.4	503.5	436.3	-13.3%
Цайр	мян.тонн	14.4	65.9	73.6	11.6%
Бусад ашигт малтмал	мян.тонн	0.6	2.3	1.2	-46.5%
Бусад ачаа	мян.тонн	219.4	158.8	222.9	40.3%

Зураг 30 Автотээврийн импортын ачаа




Автотээврээр 2025 онд импортын ачааны 50.5%-ийг буюу нийт 3.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 4.2%-аар өссөн үзүүлэлт байна. Импортын тээврийн 90.7%-ийг БНХАУ-тай, 9.3%-ийг ОХУ-тай хиллэдэг боомтуудаар тээвэрлэжээ.

Үүнээс Замын-Үүд боомтоор хамгийн их буюу 2.7 сая тонн ачаа импортолсон нь 68.6%-ийг эзэлж байгаа бол Гашуунсухайт боомтоор 14.6% буюу 574.8 мянган тонн, Алтанбулаг боомтоор 5.4% буюу 214.9 мянган тонн ачаа бусад боомтуудаар нийлээд 11.3%-ийг эзлэх ачаа оруулжээ.

Ачаа тээвэр боомтуудаар	2024 он		2025 он	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
<b>Нийт ачаа, мян.тонн</b>	<b>3,783.4</b>	<b>84,028.3</b>	<b>3,943.4</b>	<b>92,583.1</b>
Алтанбулаг	234.7	29.1	214.9	37.4
Арцсуурь	1.5	0.03	1.0	0.03
Бичигт	31.9	4,077.0	25.6	5,799.7
Баянхошуу	21.1	504.5	7.8	436.6
Бургастай	1.5	706.4	1.7	698.3
Булган	60.2	3,932.9	90.7	3,375.9
Боршоо	52.0	0.2	33.6	0.2
Гашуунсухайт	439.3	40,310.6	574.8	42,558.5
Замын-Үүд	2,591.6	1,009.3	2,706.1	911.7
Цагаан нуур	150.7	2,520.9	115.4	6.9
Ханги	26.3	8,650.2	20.3	6,184.3
Хавирга	53.5	273.7	74.6	287.6
Шивээ хүрэн	113.9	24,531.2	74.4	32,285.4
Сүмбэр	0.1	0.4	0.01	0.3
БНХАУ	3,343.3	83,996.4	2,577.9	92,538.4
ОХУ	440.1	31.9	365.4	44.7
<b>Нийт</b>	<b>87,811.7</b>		<b>96,526.5</b>	

Зураг 31 Боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгсэл, эзлэх хувь



Автозамын боомтуудаар 2025 онд нийт 1,010,217 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бол үүнээс 159,263 ачаатай тээврийн хэрэгсэл хилээр орсон, 850,954 ачаатай тээврийн хэрэгсэл хилээр гарсан байна.


БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 954,228 болж өмнөх оноос 9.7%-аар нэмэгдсэн нь нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн 94.5%-ийг эзэлж байна. 2023 онд энэ үзүүлэлт 87.1%, 2024 онд 92.2%-ийг эзэлж байжээ.

ОХУ-тай хиллэдэг боомтуудаар 55,989 мянган тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 24.1%-аар буурсан ба хил нэвтэрсэн нийт тээврийн хэрэгслийн 5.5%-ийг эзэлж байна.

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2023 он	2024 он	2025 он	2025/2024
<b>Орсон тээврийн хэрэгсэл</b>	<b>223,224.0</b>	<b>148,588.0</b>	<b>159,263.0</b>	<b>7.2%</b>
БНХАУ-аас	202,331.0	112,872.0	137,435.0	21.6%
Бичигт	-	300.0	150.0	-50.0%
Баянхошуу	476.0	422.0	58.0	-86.3%
Булган	624.0	0.0	257.0	-
Бургастай	3.0	9.0	0.0	-100.0%
Гашуунсүхэйт	4,915.0	8,743.0	7,428.0	-15.0%
Шивээхүрэн	131,500.0	3,281.0	5,158.0	57.2%
Замын-Үүд	64,209.0	98,555.0	122,870.0	24.7%
Ханги	168.0	734.0	540.0	-26.4%
Хавирга	436.0	828.0	974.0	17.6%
ОХУ-аас	20,893.0	35,716.0	52,905.0	-38.9%
Алтанбулаг	12,686.0	13,484.0	12,405.0	-8.0%
Боршоо	1,461.0	2,150.0	32,490.0	-34.3%
Цагааннуур	6,746.0	20,082.0	8,010.0	-60.1%
<b>Гарсан тээврийн хэрэгсэл</b>	<b>700,290.0</b>	<b>794,821.0</b>	<b>850,954.0</b>	<b>7.1%</b>
БНХАУ-руу	601,983.0	756,759.0	816,793.0	7.9%
Бичигт	38,159.0	47,894.0	44,667.0	-6.7%
Баянхошуу	16,232.0	13,784.0	11,825.0	-14.2%
Булган	34,526.0	48,696.0	45,136.0	-7.3%
Бургастай	4,807.0	14,765.0	14,910.0	1.0%
Гашуунсүхэйт	266,259.0	331,317.0	393,796.0	18.9%
Шивээхүрэн	166,263.0	198,651.0	240,480.0	21.1%
Замын-Үүд	6,829.0	13,695.0	11,623.0	-15.1%
Ханги	65,713.0	85,714.0	52,121.0	-39.2%
Хавирга	3,069.0	2,243.0	2,235.0	-0.4%
ОХУ-руу	98,307.0	38,062.0	34,161.0	-10.2%
Алтанбулаг	84,151.0	11,253.0	24,162.0	114.7%
Боршоо	1,387.0	2,158.0	1,400.0	-35.1%
Цагааннуур	12,769.0	24,651.0	8,599.0	-65.1%

## МОНГОЛ УЛСАД 1 418 891 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БҮРТГЭЛТЭЙ БАЙНА.

Зураг 32 Тээврийн хэрэгслийн ангилал




